# ОРХОН АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2020 ОНЫ БҮТЭН ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ТАСГИЙН ДАРГА,
АХЛАХ БҮРТГЭГЧ Ө.ГАНЗОРИГ

ХЯНАСАН:
ОРХОН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА М.ОТГОНБАЯР

2020-12-11



## 1. БОДЛОГЫН ЗОРИЛТЫГ ХАНГАХ ТАЛААР

Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь тайлант хугацаанд Орхон аймгийн 2 сум, 26 багийн нийт 105000 иргэнд Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний бүртгэлийн тухай хууль, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдлөгө болгон,

Улсын бүртгэлийн ерөнхий газраас өгсөн удирдамж, чиглэлийн дагуу иргэний, эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой бусад эрхийн, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйл ажиллагааг орон нутагт эрхлэн зохион ажиллаж байна.

Тус хэлтэс нь Орхон аймгийн хэмжээнд үйл ажиллагаагаа иргэдэд дараах 4 цэгээс хүргэж байна. Үүнд:

- Оюут багт байрлах Захиргааны II байр /УБХ байрлаж буй байр/
- Аймгийн ЗДТГ-ын “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”

- Гэр хорооллын эцэст байрлах “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”
- Жаргалант сумын ЗДТГ

2020 онд тус хэлтэс үйл ажиллагаагаа Монгол Улсын Их Хурлын болон АНСДИТХ-ын ээлжит сонгуулийн бэлтгэл ажлыг ханган хуулийн дагуу зохион байгуулах, иргэд, үйлчлүүлэгчдийг ая тухтай үйлчлүүлэх нөхцлөөр хангахад голлон анхаарч ажиллаа.

Тайлангийн хугацаанд УБЕГ-аас ирүүлсэн “Улсын бүртгэлийн цахим мэдээллийн санг ашиглах, түүний хадгалалт, хамгаалалт, нууцлалын аюулгүй байдлыг хангах журам”, “УБЕГ-т холбогдох хууль, хяналтын байгууллагаар шийдвэрлэгдэж байгаа хэрэг маргааны явцад хяналт тавих журам”, “УБЕГ-ын Хөдөлмөрийн дотоод журам”, “Хадгалах хэргийн нэрийн жагсаалт”-ын хадгалах хугацаанд оруулах санал зэрэг баримт бичгүүдийн төсөлд санал хүргүүлсэн.

### *1.2. Хүний нөөцийн талаар*

Тус хэлтэс нь 2020 оны 11 дүгээр сарын байдлаар Удирдах –1, гүйцэтгэх –18, үйлчлэх –5, гэрээт –2, түр гэрээт -4 нийт 30 албан хаагчтай ажиллаж байгаа бөгөөд хүүхэд асрах чөлөөтэй байгаа 4 албан хаагчийн мэдээллийг “Хөдөлмөрийн дотоод журам”-д заасны дагуу УБЕГ-т тухай бүр нь хүргүүлж ажилласан бөгөөд цахим хуудсанд байршуулсан.

Тайлант онд хүүхэд асрах чөлөө авсан 2 төрийн захиргааны албан хаагчийн сул орон тоонд Аймгийн Төрийн албаны салбар зөвлөлөөс ирүүлсэн Төрийн албаны нөөцөд бүртгэлтэй 2 иргэнийг түр томилуулсан.







ХАСХОМ мэдүүлэг гаргах албан хаагчид ХАСХОМ-ээ хуулийн хугацаанд гарган холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлэн ажилласан.

Тайлангийн хугацаанд УБЕГ-ын даргын 2020 оны Б/15 дугаар тушаалаар Улсын бүртгэгч М.Цогтбаатар 2020-01-20 ны өдрөөс Хуулийн этгээдийн Улсын бүртгэгчээр томилогдсон.

УБЕГ-ын даргын 2020 оны Б/45 дугаар тушаалаар Улсын бүртгэгч О.Анхбаярыг 2020-01-29 ны өдрөөс хүүхэд асрах чөлөөг дуусгавар болгон үүрэгт ажилд нь үргэлжлүүлэн ажиллуулсан.

УБЕГ-ын даргын 2020 оны Б/61 дугаар тушаалаар Хэлтсийн дарга Д.Мөнхболдод сахилгын шийтгэл ноогдуулсан.

УБЕГ-ын даргын 2020 оны Б/63 дугаар тушаалаар Улсын ахлах бүртгэгч Ө.Ганзоригийг Хэлтсийн даргыг томилогдох хүртэл албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсон.

УБЕГ-ын даргын 2020 оны Б/183 дугаар тушаалаар Улсын бүртгэгч Н.Түвшинжаргалын туршилтын хугацааг дуусгавар болгон 2020-04-13 ны өдрөөс албан тушаалд томилсон.

УБЕГ-ын даргын 2020 оны Б/184 дугаар тушаалаар Улсын бүртгэгч М.Жавзансүрэг 2020-04-13 ны өдрөөс хүүхэд асрах чөлөөг дуусгавар болгон үүрэгт ажилд нь үргэлжлүүлэн ажиллуулсан.

УБЕГ-ын даргын 2020 оны Б/220 дугаар тушаалаар Р.Долгорсүрэнг 2020-04-27 ны өдрөөс Г.Наранчимэгийн жирэмсний болон амаржсаны амралт, хүүхэд асрах чөлөө дуусах хүртэл хугацаанд албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэхээр томилсон

УБЕГ-ын даргын 2020 оны Б/221 дугаар тушаалаар А.Баярмааг 2020-04-27 ны өдрөөс Ц.Оюунсүрэнгийн жирэмсний болон амаржсаны амралт, хүүхэд асрах чөлөө дуусах хүртэл хугацаанд албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэхээр томилсон

### *1.1 Албан хаагчдын сургалтын талаар*

2020.03.06 нд УБЕГ-аас зохион байгуулсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Сонгогчдын нэрийн жагсаалтын удирдлага программын талаархи онлайн сургалтад Иргэний бүртгэлийн тасгийн ахлах бүртгэгч, мэдээлэл технологийн ажилтан, улсын бүртгэгчид хамрагдсан.

2020.03-09 нд УБЕГ-аас зохион байгуулсан төрийн албан хаагчын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, тайлагнах талаархи онлайн сургалтад нийт төрийн захиргааны албан хаагчид хамрагдсан.

2020.04.21 нд Иргэний бүртгэлийн ахлах бүртгэгч нийт албан хаагчдад Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль болон холбогдох хууль, тогтоомжийн талаар сургалт зохион байгуулсан.

2020.04.22 нд УБЕГ-аас зохион байгуулсан Иргэний бүртгэлийн шинэ системийн талаархи онлайн сургалтад улсын ахлах бүртгэгч Ө.Ганзориг, улсын бүртгэгч Н.Түвшинжаргал, Б.Мөнхтуяа нар хамрагдсан.

2020.04.29 нд “Хөдөлмөрийн аюулгүй байдал-Эрүүл ахуйн сарын аян”-ы хүрээнд “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын АУ-ны доктор кл. Профессор, мэргэжлээс шалтгаалах өвчны эмгэг судлаач эмч Ж.Жавзмаагаар ажлын байран дахь ХАБЭА, ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх талаар зохион байгуулсан сургалтад нийт албан хаагчид оролцсон.

2020.05.08 нд УБЕГ-ын Хяналт шалгалтын газраас зохион байгуулсан сургалтад хяналтын улсын байцаагч Г.Энхтуяа хамрагдсан.

2020.05.13 нд Орхон аймаг дахь Тагнуулын газрын холбогдох ажилтнаас зохион байгуулсан “Төрийн болон албаны нууцын тухай” хуулийн талаархи сургалтад нийт албан хаагчид хамрагдсан.

2020-05-26 нд УБЕГ-аас зохион байгуулсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар” зохион байгуулсан онлайн сургалтад ахлах бүртгэгчид, хяналтын улсын байцаагч хамрагдсан.

2020-05-27 нд УБЕГ-аас зохион байгуулсан “Хүний эрхийн талаархи” онлайн сургалтад ахлах бүртгэгчид, хяналтын улсын байцаагч хамрагдсан.

2020.06.15 нд сонгуулийн 20 тойрогт Итгэмжлэгдсэн ажилтнаар ажиллах ажилтнуудад “Эрх зүйн” сургалтыг онлайнаар зохион байгуулсан.

2020.06.11-12 ны өдрүүдэд сонгуулийн 20 тойрогт Итгэмжлэгдсэн ажилтнаар ажиллах ажилтнуудад “Ирц бүртгэлийн программын талаархи” мэдээлэл технологийн сургалтыг танхимаар зохион байгуулсан.

2020.09.04 нд УБЕГ-аас зохион байгуулсан АНСДИТХ-ын сонгуулийн тухай хуулийн онлайн сургалтад хэлтсийн дарга, ахлах бүртгэгч, хяналтын улсын байцаагч хамрагдсан.

2020.09.07 нд АНСДИТХ-ын сонгуульд Итгэмжлэгдсэн ажилтнаар ажиллах ажилтнуудад “Эрх зүйн” сургалтыг онлайнаар зохион байгуулсан.

2020.09.09-10 ны өдрүүдэд Орхон аймаг дахь Төрийн албаны салбар зөвлөл, Удирдлагын академаас хамтран зохион байгуулсан “Төрийн албан хаагчдын сургалтын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх” сэдэвт сургалтад хэлтсийн дарга, иргэний бүртгэлийн ахлах бүртгэгч хамрагдсан.

2020.10.02-03 ны өдрүүдэд АНСДИТХ-ын сонгуульд Итгэмжлэгдсэн ажилтнаар ажиллах ажилтнуудад “Ирц бүртгэлийн программын талаархи” мэдээлэл технологийн сургалтыг танхимаар зохион байгуулсан.

2020.11.11-12 ны өдрүүдэд Хөгжлийн бэрхшээлтэй иргэний дохионы хэлний ахисан шатны сургалтад улсын бүртгэгч Н.Алтанцэцэг, Э.Оюунбат нар тус тус хамрагдсан.

## 3. ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

### *3.1. Эд хөрөнгө амчлөх, эзэмших, ашиглах, эрхийг бүртгэж баталгаажуулах талаар*

2020 оны 01 сарын 01-ний өдрөөс эхлэн EPRS II программыг бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглан иргэн, хуулийн этгээдээс 16611 мэдүүлэг, нотлох баримтыг хүлээн авч улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн. Үүнд:

Анхны бүртгэл -1356

Өмчлөх эрх шилжүүлэх-3384

Барьцааны гэрээ-10843

Бүртгэлд өөрчлөлт оруулах-571

Бусад-35

Лавлагаа, хуулбар -344

Урьдчилсан тэмдэглэл-78







## 4. ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

### 4.1 Иргэний үнэмлэх олголтын талаар

Тайлангийн хугацаанд нийт 5333 иргэнд иргэний үнэмлэх олголоо. Нийт иргэний үнэмлэхний 1205 нь 16 нас хүрч анх удаа иргэний үнэмлэх авч буй иргэд байна.

Мөн иргэний үнэмлэхний хугацаа дууссан иргэдийн 25 болон 45 насны сунгалт 2641, хаяж үрэгдүүлсэн болон бусад шалтгаанаар 1487 иргэний үнэмлэх олголоо.

Тайлангийн хугацаанд гадаадад ИШБ-д орж бүртгүүлсэн болон 25, 45 насны сунгалт хийлгэсэн 65, цахимаар иргэний үнэмлэх захиалсан 14 иргэний мэдээлэлд баталгаажилт хийгдсэн.

### 4.2 Иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн талаар

Тайлангийн хугацаанд иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн чиглэлээр нийт 3421 бүртгэл хийгдсэнээс 2227 төрөлт, 374 гэрлэлт, 142 гэрлэлт дуусгавар болсон, 2 гэрлэлт сэргээлт, 59 хүүхэд үрчлэлт, 73 овог, эцгийн нэр, нэр өөрчилсний бүртгэл, 64 эцэг тогтоосны бүртгэл, 480 нас барсны бүртгэл хийн сар бүрийн мэдээ, тайлан, ИУБ маягтуудыг УБЕГ-т хугацаанд нь хүргүүлэн ажиллаа.






Мөн тайлангийн хугацаанд төрсний гэрчилгээ 416, гэрлэсний гэрчилгээ 26 ширхэгийг дахин олгож 16 иргэнд регистрийн дугаар өөрчилсний бүртгэл хийсэн.

### 4.3 ҮҮндэсний энгийн гадаад паспорт олголтын талаар

2020 онд нийт 1246 иргэнээс гадаад паспортын материал бүрдүүлэн авч, Орхон аймгийн Тагнуулын газрын шуудангаар явуулж иргэдэд түргэн шуурхай олгох ажлыг зохион байгуулж ирлээ.

Covid-19 холбоотойгоор иргэдээс гадаад паспортын материал бүрдүүлэн захиалах тоо эрс багассан. Тухайлбал 2019 онд тус хэлтэст 3113 иргэн гадаад паспорт авах хүсэлт гарган захиалга өгч байсан бол 2020 онд 1246 иргэн гадаад паспорт авах хүсэлт гаргасан нь өмнөх жилээс 1867-оор бага байна.

### 4.4 Иргэн шилжин суурьших хөдөлгөөний талаар

2020 онд иргэний шилжилт хөдөлгөөн

| № | Шилжилт хөдөлгөөний төрөл | 16-аас дээш насны иргэн | 16-аас доош насны хүүхэд | Нийт |
|---|---|---|---|---|
| 1 | Аймаг хот хооронд | 829 | 467 | 1296 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2 | Сум хооронд | 67 | 20 | 87 |
| 3 | Баг хооронд | 2186 | 1044 | 3230 |
| **Нийт** | | **3082** | **1531** | **4613** |

Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хууль, УБЕГ-ын даргын 2020 оны 01 дүгээр сарын 27 ны өдрийн А/126 дугаар тушаалаар 2020 оны 02 дугаар сарын 01 ний өдрөөс МУИХ-ын ээлжит сонгуулийн санал авах өдрийг дуусах хүртэл хугацаанд иргэний шилжилт хөдөлгөөнийг түр зогсоосон.
Мөн АНСДИТХ-ын сонгуулийн тухай хууль, УБЕГ-ын даргын 2020 оны 08 дугаар сарын 2020.08.07 ны өдрийн А/1168 тушаалаар 2020.08.16 ны өдрөөс түр зогсоон ажилласан болно.зогсоосон.

### *4.4 Иргэний бүртгэлийн лавлагаа олголтын талаар*

Тайлангийн хугацаанд иргэний баримтын архиваас нийт 13482 лавлагаа олгосон бөгөөд үүнээс хууль хяналтын байгууллагад 3226, иргэдэд 10256 лавлагаа олгосон.

## 5.ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

### *5.1 Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн талаар*

2020 оны жилийн эцсийн байдалаар шинээр байгуулагдсан 199 хязгаарлагдмал хариуцлагатай компани, хоршоо 1, төрийн бус байгууллага 41 тус тус улсын бүртгэлд бүртгэж, нийт 241 улсын бүртгэлийн гэрчилгээ олголоо.

Тайлангийн хугацаанд 459 хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэж, улсын бүртгэлийн гэрчилгээнд нь холбогдох бичилтийг хийж баталгаажуулж, архивт шилжүүлсэн болно.

Улсын бүртгэлийн гэрчилгээгээ үрэгдүүлсэн, солих хүсэлт гаргасан 75 хуулийн этгээдийн баримт бичгийг хүлээн авч хянан үзээд дахин улсын бүртгэлийн гэрчилгээ олголоо. Салбарын 16 гэрчилгээ олгосон байна.

Иргэн, хуулийн этгээд тамга, тэмдэг, баталгааны тэмдэг хийлгэх, ашиглах үйл ажиллагаанд хяналт тавих журмын хэрэгжилтийн хүрээнд 336 хуулийн

этгээдэд тамга, тэмдэг хийлгэх хяналтын хуудас олгож, 111 хуулийн этгээд тамга, тэмдгээ хураалгасан байна. Жилийн эцсийн байдлаар нийт 1238 бүртгэлийг цахим санд бүртгэж баталгаажуулсан байна.

Мөн нэрийн баталгаажилт ххк-207 хоршоо-3 холбоо/НҮТБ,ГҮТБ/-38 үйлдвэрчний эвлэл-27 сан-2 нөхөрлөл-2 тус тус баталгаажилт хийсэн ба 56-н оноосон нэр давхардсан талаар хариу өгч ажилласан. Нийт 279 оноосон нэрийн баталгаажилт хийсэн.....

Мөн 2020 оны 01 дүгээр сарын 01 нээс Татварын багц хуулийн өөрчлөлт орсонтой холбоотойгоор 241 шинээр байгуулагдсан хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн хуулийн хүрээнд тогтоож, цахим санд шинээр бүртгэгсэн. 386 нэмэлт өөрчлөлт хийлгэсэн нийт 627 хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг нөхөн бүртгэх ажлыг зохион байгуулсан.

## 5. БҮРТГЭЛИЙН АРХИВЫН ЧИГЛЭЛЭЭР

2020 онд Иргэний бүртгэл үйл ажиллагаатай холбоотоы архивын эх нотлох баримт-7265 /төрөлт-2227, үрчлэлт-59, ОНӨ-73, эцэг тогтоолт-64, гэрлэлт-374, гэрлэлт дуусгавар болсон-142, нас баралт-480, цахим үнэмлэх шинээр болон 25, 45 насны сунгалт-3846/

-Эд хөрөнгийн архив-16611 /Анхны бүртгэл 1356, өмчлөх эрх шилжүүлэх 3384, барьцааны эрхтэй холбоотой бүртгэл 10843, бүртгэлд өөрчлөлт оруулах 571, бусад 35, лавлагаа, хуулбар 344, урьдчилсан тэмдэглэл 78/

-Хуулийн этгээд-700 /Шинэ-241, нэмэлт өөрчлөлт-459/

Нийт 3824 бүртгэлээр архивын нэгж нэмэгдэж, 24576 бүртгэлийн баяжилтыг хууль журмын дагуу архивт хүлээн авч хадгалалт, хамгаалалтыг ханган ажиллаж байна.





Архивын тухай хууль тогтоомжийн дагуу архивын өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээ, агааржуулалт, чийгшил, дулааныг хэмжин ажиллаж байна.

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивт зуны улиралд борооны ус орж хувийн хэрэг норгож улмаар архив чийгшин мөөгөнцөр үүсч байсныг орон нутгийн удирдлагад танилцуулан бороны ус зайлуулах хаялга шинээр хийлгэснээр Эд хөрөнгийн бүртгэлийн архивт ус орох байдал арилсан.




Иргэний бүртгэлийн архивт хувийн хэрэгтээ ороогүй 17 мянга орчим ХААТР, ИУБ маягтуудыг шалган 1539 иргэний хувийн хэрэг болон ХААТР, ИУБ маягтуудыг холбогдох аймгуудад хүргүүлэн бусад маягтуудыг хувийн хэрэгт нь оруулан баяжилт хийн Иргэний баримтын архивыг цэгцэллээ.

## 6 . АЛБАН БИЧГИЙН ЭРГЭЛТ, ТУШААЛ, ШИЙДВЭР, ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ТАЛААР

### *6.1. Албан бичгийн эргэлтийн талаар*

Тайлангийн хугацаанд тус хэлтэс нийт 2261 албан бичиг хүлээн авснаас хариутай 1625 бичгийн хариуг хүргүүлэн ажилласан.

Мөн хугацаанд тус хэлтсээс бусад байгууллагад 1456 албан бичиг хүргүүлсэн.

2020 онд албан бичиг эргэлтийн чиглэлээр:

| Баримт бичиг | Баримт бичгийн тоо | Нийт |
|---|---|---|
| | Эх хувь | |
| Ирсэн бичиг | 2262 | 2262 |
| Явуулсан бичиг | 1456 | 1456 |
| Тушаал /хэлтсийн дарга/ | 33 | 33 |
| Тушаал /УБЕГ/ | 83 | 83 |
| Хэлтсийн шуурхайн тэмдэглэл, Даргын зөвлөлийн тэмдэглэл, хамт олны хурлын тэмдэглэл, | 20 | 20 |
| Хуулбар үнэн | 113 | 113 |
| Өргөдөл гомдол, өргөдлийн өргөдлийн дүгнэлт | 18 | 18 |
| Өргөдлийн тайлан мэдээ,/АЗДТГ, УБЕГ/ | 4 / улирал бүр / | 4 |
| Үнэт цаасны тайлан | 12 | 12 |
| Цахим архив | 2158 | 2158 |

Ирсэн албан бичгүүдийг ангилан авч үзвэл:

- Цагдаа-755 албан бичиг ирсэн байна.
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-427 албан бичиг
- Шүүх -222 албан бичиг
- Улсын бүртгэлийн ерөнхий газар болон орон нутаг дахь улсын бүртгэлийн хэлтэс- 370 албан бичиг, Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирснийг ангилан авч үзвэл
    - Тушаал-83
    - Үүрэг даалгавар-1
    - Чиглэл-25
    - Журам-7
    - Онлайн сургалт-15
- Орхон аймгийн засаг дарга болон тамгын газар- 70 албан бичиг
- Бусад байгууллага-418 албан бичиг тус тус ирсэн байна.




### *6.2. Тушаал шийдвэр, хурлын тэмдэглэлийн талаар*

Тайлангийн хугацаанд хэлтсийн даргын А тушаал 22, Б тушаал 11 гарч даргын зөвлөлийн хурлын тэмдэглэл 5, хамт олны хурлын тэмдэглэл 3, хэлтсийн шуурхайн тэмдэглэл 38 хөтлөгдсөн болно.

### *6.3. Байгууллагын архивын талаар*

Авлигатай тэмцэх газрын 2020 оны 4 дүгээр сарын 23 ны 05/5036 тоот, Архивын ерөнхий газрын Үндэсний төв архивын 2020 оны 4 дүгээр сарын 14 ны 03/331 тоот, Улсын Үндэсний төв архивын дэргэдэх баримт бичиг нягтлан шалгах арга зүйн комиссын 02 дугаар хуралдаанаас баталсан хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг/ХАСХОМ/-ийг байгууллагын архивт хүлээлгэн өгөх шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор тус хэлтэс дараах ажлыг зохион байгууллаа.

ББНШК-н 2020 оны 05 дугаар сарын 22 ны 01 дүгээр хурлаар ХАСХОМ-г байгууллагын архивт авах шийдвэрийг гаргасан.









Байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтанд ХАСХОМ нэмж бүртгэн, баримт бичгийг архивт хүлээн авах стандартын дагуу үдэж, хавтаслан 12ш хадгаламжийн нэгж үүсгэн архивт хүлээн авсан.

Авлигатай тэмцэх газрын шийдвэрт тусгасны дагуу албан хаагчийн баталгааны маягтыг бүртгэх бүртгэлийн дэвтрийг архивт хүлээн авсан



"Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааны журам"-д заасны дагуу мэдээллийн нууцлалыг ханган байгууллагын архивт хамгаалалтын шүүгээ хийж, баримтыг хадгалсан.

### 6.4. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн талаар

Тайлангийн хугацаанд иргэдээс нийт 18 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирснийг хуулийн хугацаанд шийдвэрлэн ажиллаа. Иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг ангилан авч үзвэл:

| 1. Өргөдөл, гомдлын ангилал | | | |
|---|---|---|---|
| Хүсэлт | Гомдол | Талархал | Санал |
| 9 | 7 | 1 | 1 |

| 2. Өргөдөл, гомдол хүлээн авсан хэлбэр | | |
|---|---|---|
| Бичгээр | Утсаар | Цахимаар |
| 7 | 10 | 1 |

| 3. Өргөдөл гомдлын агуулга | | | |
|---|---|---|---|
| Иргэний бүртгэлийн чиглэлээр | Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр | Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр | Бусад |
| 11 | 5 | 0 | 2 |




## 7. ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ТАЛААР

2020 онд хэлтсийн бүртгэлийн үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 3055 бүртгэлд хяналт тавьж, 14 зөрчлийг илрүүлэн зөрчлийг арилгуулахаар хяналтын байцаагчийн 6 дүгнэлт үйлдсэн, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр 773 бүртгэлд хяналт тавьж, 49 зөрчил илрүүлэн шалгалтын явцад 30 зөрчлийг тухай бүр нь арилгуулах арга хэмжээ авч ажилласан, мөн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 340 бүртгэлд хяналт тавьж, 5 зөрчлийг илрүүлэн зөрчлийг тухай бүрт нь засуулах арга хэмжээ авч ажилласан. Үүнд:

Иргэн, хуулийн этгээдээс бүртгэлийн хууль тогтоомж зөрчсөн бүртгэлийн зөрчилтэй холбоотой 106 өргөдөл, гомдлыг хүлээн авч, улсын байцаагчийн дүгнэлт үйлдэн, холбогдох газарт хүргүүлэн зөрчлийг бүрэн арилгаж шийдвэрлэсэн.

УБЕГ-ын ХШГ-аас ирүүлсэн 8/3377, 2/4861 дугаартай чиглэлийн дагуу шилжилт хөдөлгөөний 1376 бүртгэл хууль, журамд нийцсэн эсэхэд хяналт шалгалтын ажиллагаа хийж, гүйцэтгэсэн ажлын талаарх илтгэх хуудсыг тухай бүр Хяналт шалгалтын газарт хүргүүлсэн. Уг хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар мэдээллийн санд залруулга хийх тухай хяналтын улсын байцаагчийн 2794, 2846, 2796 дугаартай дүгнэлт үйлдэж, иргэний бүртгэлийн тасагт шилжүүлэн ажилласан.

УБЕГ-ын Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газраас ирүүлсэн 7/9562 дугаартай чиглэлийн дагуу тус хэлтэст бүртгэгдсэн 203 эрхийн улсын бүртгэлийг шалган бүртгэлийн зөрчлийг арилгахаар хяналтын байцаагчийн 1238 дугаартай дүгнэлт үйлдэж, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газарт хүргүүлсэн.

ХШГ-ын Хяналтын улсын ахлах байцаагчийн 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 01 дугаартай албан шаардлагын дагуу “Монгол улсын иргэнд өмчлүүлсэн газрыг хуулийн этгээдийн нэр дээр гэрээ, хэлцлээр шилжүүлсэн 2 хуулийн этгээдийн бүртгэлийг хүчингүй болгох тухай хяналтын байцаагчийн 272, 277 дугаартай дүгнэлт үйлдэн ЭХЭУБГ-т хүргүүлж, албан шаардлагын хариуг ХШГ-т хугацаанд нь хүргүүлсэн.

Улсын бүртгэлд засвар өөрчлөлт оруулахаар 14 дүгнэлт, иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд 328 бүртгэлийг хүчингүй болгох талаар улсын байцаагчийн дүгнэлт үйлдэн холбогдох газарт хүргүүлсэн.

УБЕГ-ын 2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 8/460 тоот албан бичгээр ирүүлсэн Хяналтын улсын байцаагчийн 02 дугаартай албан шаардлагын дагуу шилжилт хөдөлгөөний 514 бүртгэлд хяналт тавьж, шилжилт хөдөлгөөний бүртгэл бүртгэхдээ нотлох баримт дутуу бүртгэсэн гэх 44 зөрчил жагсаалтаар ирснийг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сан, нотлох баримттай тулган шалгаж, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч тухай

бүр холбогдох нотлох баримтыг, илтгэх хуудсын хамт ХШГ-т хугацаанд нь хүргүүлж ажилласан.

Тайлангийн хугацаанд Зөрчил шалган шийвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 6.20-д заасан хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж, зөрчил үйлдсэн 820 иргэн, 7 хуулийн этгээдээс ирүүлсэн гомдлыг хүлээн авч нийт 24,548,000 төгрөгийн торгууль оногдуулж шийдвэрлэснээр хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаан ажилласан.

## 8. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СОЁЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ, БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР

### 8.1 Иргэд байгууллагыг сурталчилгаанд хамруулсан байдлын талаар

Иргэд байгууллагад хүргэсэн сурталчилгааны хүрээнд:

2020.01.27 "Ятгах тусам нягтал" арга хэмжээний хүрээнд цагдаагийн газраас Залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн байгууллага, иргэд, олон нийтэд аяны үйл ажиллагаанд Орхон аймаг дахь Улсын бүртгэлийн байгууллага нэгдлээ.




Орхон аймгийн ЗДТГ “Ачит Ихт” ХХК-тай хамтран ажиллах гэрээний хүрээнд 2020 оны 01 сарын 24 ний өдөр Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс, Орхон аймгийн Татварын

хэлтэс, Орхон аймгийн Газрын харилцаа , барилга, хот зэрэг байгуулалтын газар байгууллагуудтай хамтран тус компаний ажилтан, албан хаагчдад Улсын бүртгэлийн байгууллагад мөрдөгдөж буй хууль тогтоомжуудын талаар мэдээлэл хийж сонирхсон асуултад хариулж зөвлөгөө, мэдээлэл өгч, гарын авлага материал тараан үйлчиллээ.







"Олон улсын хэрэглэгчийн эрхийг хамгаалах өдөр"-ийг тэмдэглэх үйл ажиллагааны хүрээнд хэлтсийн хэмжээнд дараах төлөвлөгөөг гарган хэрэгжүүлэн ажиллаа.

БАТЛАВ
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА М.ОТГОНБАЯР

**"ОЛОН УЛСЫН ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ӨДӨР"-ИЙГ ТЭМДЭГЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД ОРХОН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

| Д/д | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хугацаа | Хариуцах албан тушаалтан |
|---|---|---|---|
| 1 | "Олон улсын хэрэглэгчийн эрхийг хамгаалах өдөр"-ийг тэмдэглэх үйл ажиллагааны хүрээнд хэлтсийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган хэлтсийн даргаар батлуулах | 03.12 | Хяналтын улсын байцаагч |
| 2 | "Хариуцлагатай хэрэглэгч" сэдвийн хүрээнд иргэдэд иргэний улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр бүрдүүлэх материал, бүртгэлийн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, компанийн эцсийн өмчлөгчийг бүртгэх, цахим төлбөрийн баримтын систем"/ebarimt/ аппликейшн, burtgel.gov.mn сайтыг ашиглах талаарх мэдээллийг байгууллагынхаа цахим хуудсанд байршуулах | 03.12-03.16 | Мэдээлэл технологийн ажилтан Б.Биндэр, улсын бүртгэгч Н.Алтанцэцэг, Н.Түвшинжаргал |
| 3 | Иргэд хэлтсийн 70358989 утсаар ямар лавлагаа, үйлчилгээг асууж тодруулж мэдээлэл авч байгааг бүртгэж, иргэдийг мэдээллээр хангах | 03.12-03.16 | Улсын бүртгэгч Н.Алтанцэцэг |
| 4 | Хэлтсийн уг үйл ажиллагааны хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг баримтжуулан УБЕГ-т хүргүүлэх | 03.20-ний дотор | Мэдээлэл технологийн ажилтан Б.Биндэр, улсын бүртгэгч Н.Түвшинжаргал |

--oOo--

Уг төлөвлөгөөний дагуу тус хэлтсийн 7035-8989 утас, Аймгийн ЗДТГ-ын нэг цонхны үйлчилгээний 7035-0772 утсанд 3 сарын 13-аас 19-ний өдрүүдэд нийт 39 иргэнээс бүртгэлийн үйлчилгээний талаарх санал хүсэлтийг хүлээн авч бүртгэлийн дэвтэрт хөтлөн зөвлөгөө мэдээллийг тухай бүрт нь өгч иргэдийг мэдээллээр хanган ажиллалаа.






"ОЛОН УЛСЫН ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ӨДӨР"-ИЙГ ТЭМДЭГЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД ОРХОН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 70358989 –Т УТСАНД ДУУДЛАГА ИРСЭН ТЭМДЭГЛЭЛ

| Д/д | Дуудлага ирсэн огноо | Дуудлага ирсэн цаг минут | Дуудлагын товч утга | Дуудлага өгсөн хүний нэр |
|---|---|---|---|---|
| 1 | 2020.03.13 | 09:10 | [illegible] | [illegible] |
| 2 | 2020.3.13 | 10:19 | гэрлэлт лавлагаа [illegible] | [illegible] |
| 3 | 2020-03-13 | 10:20 | [illegible] | [illegible] |
| 4 | — | 10:25 | [illegible] | [illegible] |
| 5 | 2020.03.17 | 10:37 | [illegible] | [illegible] |
| 6 | 2020.03.13 | 14:05 | [illegible] | [illegible] |
| 7 | 2020.03.13 | 14:07 | гадаад паспорт | [illegible] |
| 8 | 2020.03.13 | 14:10 | лавлагаа | [illegible] |
| 9 | 2020.03.13 | 14:17 | Гадаад паспорт. | [illegible] |
| 10 | 03.13 | 14:20 | [illegible] | [illegible] |
| 11 | 2020.03.13 | 16:57 | [illegible] | [illegible] |
| 12 | 2020.03.14 | 11:34 | | |
| 13 | 2020.03.18 | 10:12 | [illegible] | [illegible] |
| 14 | 2020.03.18 | 11:12 | [illegible] | |
| 15 | 2020.03.18 | 11:20 | [illegible] | 99904250 |
| 16 | 2020.03.18 | 11:30 | [illegible] | 99015201 |
| 17 | 2020.03.18 | 11:40 | [illegible] | [illegible] |
| 18 | 2020.03.18 | 12:10 | [illegible] | [illegible] |




Аймгийн ЗДТГ-ын "Нэг цонхны үйлчилгээ"-ний урсдаг самбараар иргэдээс өргөдөл гомдол, санал хүсэлт хүлээж авах 7035-8989, 7035-0772 утсыг байнга үгэн зар хэлбэрээр иргэдэд мэдээлэн ажиллалаа.

"Хариуцлагатай хэрэглэгч" сэдвийн хүрээнд иргэдэд иргэний улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр бүрдүүлэх материал, бүртгэлийн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч бүртгэх, цахим төлбөрийн баримтын систем /ebarimt/ талаарх мэдээллийг байгууллагынхаа www.or.burtgel.gov.mn, www.facebook.com/orburtgel/, www.facebook.com/orkhonburtgel цахим хуудсанд байршуулан иргэдэд мэдээллийг түгээн ажиллалаа.







2020.11.10 нд “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-т “Нээлттэй хаалганы өдөр” зохион байгуулаа.





***2020*** онд Ковид-19 өвчиний улмаас бүх нийтийн болон өндөржүүлсэн бэлэн байдал тогтоосонтой холбоотойгоор “Нээлттэй хаалганы өдөрлөг” 2 удаа зохион байгуулсан бөгөөд байгууллагын үйл ажиллагааг нийгмийн сүлжээнд сурталчлах ажил түлхүү хийгдсэн болно.

Байгууллагын or.burtgel.gov.mn цахим хуудас, www.facebook.com/orkhonburtgel фэйсбүүк хуудсыг тогтмол хөтөлж, хуучин мэдээ мэдээллийг шинэчлэн тавьж, 7 хоногийн болон сар бүрийн бүртгэлийн мэдээг иргэдэд тогтмол түгээж, үйл ажиллагааг жигд ажиллуулж байна. Цахим хуудас дээр **41** , фэйсбүүк хуудсанд **71**-н шинэ мэдээ мэдээлэл тавьсан.

Хэлтсийн фэйсбүүк хуудас нь **1695** like-тай, **1759**-н дагагчтай. Фэйсбүүк хуудсан дээр нийтлэгдсэн мэдээ мэдээлэл дунджаар 500 - 1000-н хүнд тогтмол хүрдэг. Байгууллагын or.burtgel.gov.mn цахим хуудсийг улсын бүртгэлийн ерөнхий газраас гаргасан загварын дагуу шинэчлэн өөрчилж https://orkhon.burtgel.gov.mn/ гэсэн шинэ домайн хаягаар 2020 оны 11 сарын 05-ний өдрөөс эхлэн ажиллуулж байна. Цахим хуудас шинэчлэгдэн ажиллаж эхэлснээс хойш 12 сарын 10-нийг хүртэл байгууллагын үйл ажиллагаатай холбоотой **24** мэдээ мэдээллийг тавьж иргэд олон нийтэд сурталчилсан байна.

### 8.2 **Байгууллагын үйлчилгээний соёлыг дээшлүүлэх талаар**

Тайлангийн хугацаанд тус хэлтсээр үйлчлүүлж буй нялх хүүхэдтэй эхчүүд болон балчир насны хүүхдүүдийг саатуулах, хуурайлах, хөхүүлэх булан бэлтгэн тохижуулсан.





Тайлангийн хугацаанд Угтах үйлчилгээ хариуцсан ажилтан 5300 гаруй иргэнд мэдээлэл, зөвлөгөө өгч, үйлчлүүлэгчдэд шаардлагатай бичиг баримтуудыг хувилж өгсөн.



## 9. МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ТАЛААР

2020 онд мэдээллийн нэгдсэн сүлжээний байнгын тасралтгүй ажиллагааг ханган ажиллаа.

Гэр хороололд байрлах “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-д байрлах бүртгэлийн хэлтсийн “шилэн кабель” тасарсныг олж тогтоон орон нутгийн төсвөөс 1,334,398 төгрөгийн санхүүжилт гаргуулан гагнаас хийн засварлан хэвийн ажиллагаанд оруулсан.







Тайлангийн хугацаанд иргэний бүртгэлийн мэдээллийн санд нэвтрэх эрх нээх 6, нэвтрэх эрх хязгаарласан 2, хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээллийн санд нэвтрэх эрх нээх 4, нэвтрэх эрх хязгаарласан 1, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн мэдээллийн санд нэвтрэх эрх нээх 1 хүсэлтийг тус тус УБЕГ-т хүргүүлэн мэдээллийн санд нэвтрэх эрх нээх, хязгаарлах ажил хийгдсэн.

Мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр 2020.05.13 нд Орхон аймаг дахь Тагнуулын газрын холбогдох ажилтнаас зохион байгуулсан “Төрийн болон албаны нууцын тухай” хуулийн талаархи сургалтад нийт албан хаагчид хамрагдсан.

Мөн нийт албан хаагчид сар бүр компъютерийн болон мэдээллийн санд нэвтрэх кодыг сольж, мэдээллийн санд нэвтэрсэн болон мэдээллийн сангаас гарсан тэмдэглэл хөтөлж хэвшсэн.

Бүртгэлийн тоног төхөөрөмжид засвар үйлчилгээ үзүүлэх чиглэлээр 1 хурууны хээ уншигч төхөөрөмж, 2 принтер, 5 суурин компъютерын үйлдлийн систем гэмтсэнийг форматлан засвар үйлчилгээн хийн хэвийн ажиллагаанд оруулсан.

Мөн 1 компъютерийн эвдрэлийг засварлахдаа журмын дагуу тагнуулын ажилтныг байлцуулж засварлан лацыг шинэчлэн болно.

2020 оны Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуульд улсын бүртгэлийн Итгэмжлэгдсэн ажилтнаар ажиллах 70, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит сонгуульд ажиллах 40 Итгэмжлэгдсэн ажилтныг “Ирц бүртгэлийн систем”-ийн программын сургалтад хамруулан нууцын баталгаа гаргуулан авсан.

УБЕГ-аас ирүүлсэн “Улсын бүртгэлийн цахим мэдээллийн санг ашиглах, түүний хадгалалт, хамгаалалт, нууцлалын аюулгүй байдлыг хангах журам”-ын төсөлд санал хүргүүлсэн.

### 1. *Батлагдсан төсвийн хүрээнд хэлтсийн мөнгөн хөрөнгө үр ашигтай, хэмнэлттэй захиран зарцуулна.*

Тайлант онд тус хэлтэст Улсын бүртгэл, мэдээлэл хөтөлбөрийн нийт 5 арга хэмжээ хэрэгжсэн бөгөөд дээрх арга хэмжээг санхүүжүүлэх үндсэн үйл

ажиллагааны санхүүжилт 392,2 сая.төгрөг, нэмэлт санхүүжилтийн 107,3 сая.төгрөг, нийт 499,5 сая.төгрөгийн төсвийн зарцуулалтын эрх нээгдсэн. Батлагдсан төсвийг хөтөлбөр, арга хэмжээ, зардлын бүлэг зүйлийн дагуу хугацаанд нь зарцуулан ажиллаж байна.

**Батлагдсан төсөв, зарцуулалт / арга хэмжээ тус бүрээр /**

*төгрөгөөр*

| № | Арга хэмжээний нэр | Батлагдсан төсөв | Зарцуулалт | Хэмнэлт /хэтрэлт/ |
|---|---|---|---|---|
| 1 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 391,865,300.00 | 391,754,290.00 | 111,010.00 |
| 2 | Туслах үйл ажиллагааны зардал | 25,200,000.00 | 25,200,000.00 | - |
| 3 | Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал | 384,600.00 | 384,600.00 | - |
| 4 | УИХ-ын сонгууль | 52,402,200.00 | 52,395,257.00 | 6,943.00 |
| 5 | Орон нутгийн сонгууль | 29,719,000.00 | 29,543,058.00 | 175,942.00 |
| | **ДҮН** | **499,571,100.00** | **499,277,205.00** | **293,895.00** |

Төсөв, зардлыг бууруулах чиглэлээр дараах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Үүнд :

1. Ажлын цагийн ашиглалтанд хяналт тавин ажлын цагийг хурууны хээгээр бүртгэн, хоцорсон минут цагаар цалингаас хасч тооцсоноор тайлант онд 183,260 төгрөг хэмнэсэн нь 2019 оны мөн үеэс 69,9 хувиар буурсан байна.
2. 2020 оны батлагдсан төсөвт байрны түрээсийн болон аудитын төлбөрийн өр үүссэн байсныг УБЕГ-н Санхүү, төлөвлөлтийн газарт хандан тооцоо судалгаагаа хүргүүлэн 2 удаагийн тодотгол оруулан 1290,0 мянган төгрөгийн төсөв шийдвэрлүүлсэн.
3. Зайлшгүй шаардлагатайгаас бусад өрөөний суурин утсыг хаалгаснаар шуудан холбооны зардал өмнөх оноос 260,666 төгрөгөөр буюу 25,4 хувиар буурсан байна.

## *2. Үйлчилгээний орлого төвлөрүүлэлт*

Тус хэлтэс нь 2020 онд 320,0 сая.төгрөгийн орлого улсын төсөвт төвлөрүүлэхээс 2020 оны 12 дугаар сарын 01-ны байдлаар 280,5 сая.төгрөгийг хугацаанд нь төвлөрүүлсэн бөгөөд төлөвлөгөөний биелэлт 87,6 хувьтай байна. Өмнөх жилүүдэд орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлдэг байсан боловч

тайлант хугацаанд цар тахлын улмаас хөл хорио тогтоож, ажлын богиносгосон цагаар ажиллаж байгаа нь орлогын төлөвлөгөөний биелэлт тасалдахад хүрч байна.

**Орлогын төлөвлөгөөний биелэлт / 2017 – 2020 он /**

*сая төгрөгөөр*

| № | Он | Төлөвлөгөө | Биелэлт | Биелэлт /хувь/ |
|---|---|---|---|---|
| 1 | 2017 он | 320.00 | 345.70 | 108.0% |
| 2 | 2018 он | 320.00 | 367.70 | 114.9% |
| 3 | 2019 он | 320.00 | 331.40 | 103.6% |
| 4 | 2020 он | 320.00 | 280.50 | 87.7% |

### 3. *Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ, улирлын санхүүгийн тайланг холбогдох тодруулгын хамт хуульд заасан хугацаанд ерөнхий газарт хүргүүлнэ.*

УБЕГ-ын Санхүү, төлөвлөлтийн газарт дараах нэр төрлийн мэдээ, тайланг “Төсвийн тухай хууль”-д заасан хугацаанд нь сар, улирал бүр цахим шуудангаар болон шаардлагатай тохиолдолд эх хувиар нь хүргүүлэн ажиллаж байна.

**Мэдээ, тайлан хүргүүлсэн хугацаа**

| № | Мэдээ, тайлангийн төрөл | 1 сар | 2 сар | 3 сар | 4 сар | 5 сар | 6 сар | 7 сар | 8 сар | 9 сар | 10 сар | 11 сар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ / багц / | 1.31 | 3.02 | 4.01 | 5.01 | 6.02 | 7.01 | 7.31 | 9.01 | 9.30 | 11.02 | 12.01 |
| 2 | Үйлчилгээний орлогын мэдээ | 1.31 | 3.04 | 3.26 | 5.01 | 6.02 | 6.30 | 8.03 | 9.01 | 9.28 | 10.29 | 12.02 |
| 3 | Цахим үнэмлэхний тайлан | 1.31 | 3.04 | 3.27 | 5.01 | 6.02 | 6.30 | 8.03 | 9.01 | 9.30 | 11.02 | 12.02 |
| 4 | Үнэт цаасны тайлан | 1.31 | 3.05 | 4.03 | 5.05 | 6.03 | 7.02 | 8.04 | 9.04 | 10.05 | 11.04 | 12.04 |
| 5 | Улирлын Санхүүгийн тайлан, тодруулгын хамт | - | - | - | 4.13 | - | - | 7.06 | - | - | 10.07 | - |

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.1-д “*Төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагддаг төсвийн шууд захирагч нь жилийн төсвийн төслөө жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор харьяалах төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэх*“ гэж заасны дагуу тус хэлтсийн 2021 оны

төсвийн төсөл, 2022-2023 оны төсвийн төсөөллийг 2020 оны 06 дугаар сарын 22-ны өдөр хуулийн хугацаанд нь албан бичгээр болон цахим шуудангаар тус тус УБЕГ-т хүргүүлсэн болно.

**4. *2020 оны үнэт цаас, маягтыг үр ашигтай, хэмнэлттэй захиран зарцуулж, өмч хөрөнгийн тооллого хийнэ.***

2020 онд тус хэлтсийн хэмжээнд нийт 318 ширхэг үнэт цаас хүчингүй болсон бөгөөд үүний 226 ширхэг нь бүртгэгчийн, 92 ширхэг нь техникийн алдаанаас тус тус болсон байна. Аймаг, сумын 15 улсын бүртгэгч дээр бүртгэгчийн алдаанаас болслн хүчингүй үнэт цаасны 89,983 төгрөгийн төлбөр тавигдсан байна.

Өнгөрсөн онтой харьцуулахад хүчингүй болсон үнэт цаасны тоо 20,9 хувиар буурсан үзүүлэлттэй байна.




2020 оны жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг журмын дагуу 2020 оны 12 дугаар сарын 23-наас 27-ны өдрүүдэд явуулахаар төлөвлөн ажиллаж байна.



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум, Урт булаг баг, Ханддоржийн гудамж, Утас/Факс: 70350826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn
2020.07.12 № 06
танай ________ -ны № ________ -т

ОРХОН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА М.ОТГОНБАЯР ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**5. *Хэлтсийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хуульд заасан хугацаанд аудитын байгууллагаар аудит хийлгэж, зөрчил бага илэрсэн байна. Зөвлөмжийн хэрэгжилтийг хангасан байна.***

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д "*Төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид,*

*жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх" гэж* заасны дагуу 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг 2020 оны 01 дүгээр сарын 21-ны өдөр Аймгийн Төрийн Аудитын газарт хүргүүлсэн бөгөөд 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдөр **"ЗӨРЧИЛГҮЙ"** санал дүгнэлт авсан болно.

2019 оны Санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж өгсөн бөгөөд зөвлөмжийн хэрэгжилтийг 2020 оны 06 дугаар сарын 15-ны өдөр гарган Аймгийн Төрийн Аудитын болон УБЕГ-ын Бодлого төлөвлөлтийн газруудад тус тус хүргүүлсэн болно.

## 6. *Орон нутгийн удирдлага, бусад байгууллагатай хамтран ажилласан байдал*

2020 онд тус хэлтэс нь орон нутгийн удирдлагатай хамран ажиллаж орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 10,8 сая.төгрөг, Засаг даргын нөөц сангаас 25,2 сая төгрөг, Аймгийн Засаг даргын тамгын газраас 6,7 сая.төгрөгийн нийт 42,7 сая.төгрөгийн санхүүжилт тус тус авсан болно.

**Орон нутгийн санхүүжилтээр авсан хөрөнгийн жагсаалт**

*төгрөгөөр*

| № | Зардлын нэр | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ |
|---|---|---|---|---|---|
| 1 | Гэрээт ажилтны цалин | сар | 12 | 2,100,000 | 25,200,000 |
| 2 | Хувилагч / HP LaserJet MFP M436 / | ширхэг | 1 | 3,960,000 | 3,960,000 |
| 3 | Принтер / Canon 6030 / | ширхэг | 1 | 1,439,130 | 1,439,130 |
| 4 | Сканнер / Epson 530ds / | ширхэг | 3 | 1,797,400 | 5,392,200 |
| 5 | Хувилагч / HP LaserJet MFP M433 / | ширхэг | 1 | 6,743,000 | 6,743,000 |
| | **НИЙТ ДҮН** | | | | **42,734,330** |

## 11. COVID-19 ХАЛДВАРААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ ТАЛААР

### 11.1 Зохион байгуулалтын талаар

Хэлтсийн шуурхай зөвлөгөөн дээр нийт албан хаагчдад тус тушаалыг танилцуусан. Мөн хэлтсийн даргын 2020 оны А/04 тушаалаар COVID-19 ийн эрсдлээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, бэлэн байдлыг нэмэгдүүлэх, мэргэжлийн удирдлагаар ханган ажиллах шуурхай штабыг байгуулсан.



ОРХОН АЙМАГ
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 02 сарын 19 өдөр Дугаар А/04

Шуурхай штаб байгуулах тухай

"Гамшгаас хамгаалах тухай хууль"-ийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалт, Монгол улсын Ерөнхийлөгчийн 2020 оны 02 сарын 12-ны өдрийн 10 дугаар зарлиг, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 02 сарын 12-ны өдрийн 62 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын даргын 2020 оны 02 сарын 13-ны өдрийн 04 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Шинэ төрлийн коронавирусын халдварын аюул, эрсдэл өндөр байгаа тул орон нутгийн хэмжээнд болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, бэлэн байдлыг нэмэгдүүлэх, мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллах шуурхай штабын бүрэлдэхүүнийг нэгдүгээр, үүрэг гүйцэтгэх жижүүрийн хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус батлсугай.

2.Байгууллагын шуурхай штабыг 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн үйлчилгээний танхимд байрлуулж ажиллахыг Штабын нарийн бичиг /Ц.Одгэрэл/-д даалгасугай.

3.Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг /Шуурхай штаб /Ө.Ганзориг/-т үү [illegible] болгосугай.

ДАРГА М.ОТГОНБАЯР

Мөн нийт албан хаагчдын утасны дугаар болон яаралтай үед дамжуулан холбоо барих утасны дугаарын жагсаалтыг шинэчиллээ.

Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн төлөвлөгөөнд тодотгол хийн COVID-19 ийн халдвараас хэлтсийн хэмжээнд урьдчилан сэргийлэх арга хэмжээг шуурхай зохион байгуулах төлөвлөгөөг батлан нийт албан хаагчдыг үүрэгжүүлээ.

Албан хаагчдын цагийн ирцийн бүртгэлийг Хяналтын улсын байцаагчид даалган цаасаар гарган хяналт тавин ажиллаж байна.

Хэлтсийн даргын баталсан хуваарийн дагуу "Хариуцлагатай жижүүр" ажиллуулж байна. Улсын хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдал тогтоосон болон УБЕГ-аас ажлын тусгай горимд шилжүүлсэн хугацаанд нийт 81 өдөр хариуцлагатай жижүүр ажилласан болно.

Мөн Монгол улсын Засгийн газар, УОК-ын шийдвэрээр Бүх нийтийн бэлэн байдал болон өндөржүүлсэн бэлэн байдал тогтоосон хугацаанд нийт 30 өдөр хариуцлагатай жижүүр ажиллуулсан болно.

АОК-оос өгсөн үүрэг даалгаврын дагуу Бүх нийтийн бэлэн байдал, хөл хорионы үед дэлгүүр, аптек ажиллах болсонтой холбогдуулан 11 сарын 27, 28-ний өдрүүдэд хэлтсийн албан хаагчид хүнсний дэлгүүрүүд дээр хариуцлагатай жижүүрийн үүргийг гүйцэтгэсэн.





Мөн АОК-с өгсөн үүргийн дагуу Эрдэнэт хотоос орж гарах зүүн цэг болох Жаргалант сумын пост, зүүн цэг болох Бүрэнбүстийн пост дээр тус хэлтсийн албан хаагчдын хуваарийн дагуу 11 сарын 30-ний өдрөөс 12 сарын 04- ний өдрийг хүртэл ажиллуулсан.





Постууд дээр ажиллах хугацаанд Эрдэнэт хот руу орсон 501, Эрдэнэт хотоос гарсан 231нийт 732 иргэнээс асуумж, судалгаа авч ажилласан.

Мөн иргэдэд бүртгэлийн үйлчилгээг хөнгөн, шуурхай хүргэх, олон дахин ирүүлэхгүй байх тал дээр Хяналтын улсын байцаагч, тасгийн дарга нар хяналт тавин ажиллаж байна.



Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн даргын 2020 оны 02 сарын 19-ний өдрийн 04 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

А. ШУУРХАЙ ШТАБЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭХ ЖИЖҮҮРИЙН ХУВААРЬ

| № | Овог нэр | Албан тушаал | Хуваарь | Холбоо барих утас |
|---|---|---|---|---|
| | Дуудлага хүлээн авах утас | | 2020 оны 02 сарын 19 ний өдрөөс 03 дугаар сарын 02 хүртэл | 70358989 99557263 |
| 1 | Ц.Одгэрэл | Нягтлан бодогч | 2020.02.19 Лхагва гариг | 99358217 |
| 2 | Г.Энхтуяа | Хяналтын улсын байцаагч | 2020.02.20 Пүрэв гариг | 99360669 |
| 3 | Н.Алтанцэцэг | Улсын бүртгэгч | 2020.02.21 Баасан гариг | 99037580 |
| 4 | Ө.Ганзориг | Ахлах бүртгэгч | 2020.02.22 Бямба гариг | 99557263 |
| 5 | Э.Оюунбат | Улсын бүртгэгч | 2020.02.23 Ням гариг | 88664444 |
| 6 | Б.Биндэр | Сүлжээний инженер | 2020.02.24 Даваа гариг | 95950555 |
| 7 | Б.Санчир | Архивч | 2020.02.25 Мягмар гариг | 88186989 |
| 8 | Д.Алтан-Од | Архивч | 2020.02.26 Лхагва гариг | 88035145 |
| 9 | Ж.Даваадорж | Улсын бүртгэгч | 2020.02.27 Пүрэв гариг | 99731335 |
| 10 | М.Цогтбаатар | Улсын бүртгэгч | 2020.02.28 Баасан гариг | 99007297 |
| 11 | Б.Бат-Эрдэнэ | Улсын бүртгэгч | 2020.02.29 Бямба гариг | 99222056 |
| 12 | Х.Бат-Эрдэнэ | Гэрээт ажилтан | 2020.03.01 Ням гариг | 99263646 |
| 13 | Б.Шинэбаяр | Гэрээт ажилтан | 2020.03.02 Даваа гариг | 91168948 |

Б. Шуурхай штабын 70358989, 99557263 дугаарын утасны ажиллах горим 99557263 дугаар нь хоногийн 24 цаг, 70358989 дугаар нь ажлын өдрийн 08:00 цагаас 21:00 цагийн хугацаанд ирсэн мэдээллийг бүртгэж, тусгай дэвтэрт хөтөлнө. Мэдээллийг жижүүр өглөө бүрийн 09:00 цагт шуурхай штабын даргад танилцуулна.

--oo0oo--



БАТЛАВ.
ОРХОН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА М.ОТГОНБАЯР

ШИНЭ ТӨРЛИЙН КОРОНАВИРУСЫН ХАЛДВАРААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТЭМЦЭХ ҮЕИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Энэхүү төлөвлөгөө нь Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн төлөвлөгөөний тодотгол хэсэг болно.

Төлөвлөгөөний зорилго: Шинэ төрийн коронавирус /COVID-19/-ийн халдвараас хэлтсийн хэмжээнд ур... хэмжээг шуурхай зохион байгуулах, Улсын онцгой комисс болон аймгийн онцгой комисс, Улсын бүртгэлийн ер... шийдвэрийг хэрэгжүүлэх, халдварт өвчнөөс сэргийлэх, тэмцэх ажлыг ажлыг шуурхай зохион байгуулахад оршин...

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хариуцах албан тушаалтан | Хугацаа |
|---|---|---|---|
| | **Нэг. Иргэд албан хаагчдад мэдээлэл, зөвлөгөө, сурталчилгаа хийх** | | |
| 1.1. | Үйлчилгээний танхимын нийт цонх, өрөө тасалгааны хаалган дээр иргэдэд амны хаалт зүүн үйлчлүүлэх талаар анхааруулга тавих | Б.Биндэр Х.Бат-Эрдэнэ | Байнга |
| 1.2. | Үйлчлүүлж буй иргэдэд халдвараас урьчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, ухуулга, мэдээ, мэдээлэл өгөх | Нийт албан хаагчид | Тухай бүр |
| 1.3. | "Хэлтсийн шуурхай"-д нийт албан хаагчдад Коронавирусын халдварын талаар ДЭМБ, ЭМЯ, УОК, АОК, УБЕГ-аас өгч буй албан ёсны албан ёсны мэдээ, мэдээлэл, зөвлөмж, шийдвэрийг мэдээлж байх | Ө.Ганзориг Г.Ууган-Эрдэнэ | Тухай бүр |
| 1.4 | Гадаад паспорт захиалж буй болон гадаад паспорт олгож буй иргэдэд хуваарьт нислэгүүд болон олон... | Н.Алтанцэцэг | Тухай бүр |




## 11.2. Мэдээлэл, зөвлөгөө, сурталчилгааны талаар

Хэлтсийн шуурхай зөвлөгөөн дээр нийт албан хаагчдад COVID-19 ийн халдварын талаар ДЭМБ, ЭМЯ, УОК, аймгийн Онцгой комисс болон УБЕГ-аас өгч буй албан ёсны мэдээ, мэдээлэл, зөвлөмж шийдвэрийг танилцуулан ажилласан.










Үйлчилгээний танхимын нийт цонх, өрөө тасалгааны хаалган дээр иргэдэд амны хаалт зүүн үйлчлүүлэх талаар анхааруулга тавьсан.

2020.04.29 ний өдөр “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын АУ-ны доктор, кл.профессор, Мэргэжлээс шалтгаалах өвчний эмгэг судлаач эмч Ж.Жавзмаагаар ажлын байран дахь эрүүл ахуй болон COVID-19 ийн халдвараас урьдчилан сэргийлэх талаар албан хаагчдад сургалт зохион байгууллаа.







### *11.3. Халдвараас урьдчилан сэргийлэх талаар*

Албан хаагчдын биеийн дулааныг өдөрт 2-оос доошгүй удаа хэмжин тэмдэглэл хөтөлж байна. /дух, чих, гар/. Мөн үйлчилгээний танхимаар үйлчлүүлж буй нийт иргэдийн гарыг ариутган, биеийн дулааныг хэмжсэний дараа үйлчилгээ үзүүлж байна.







Хэлтсээс албан хаагчдыг халдвараас урьдчилан сэргийлэх хүрээнд 400 ширхэг маск /амны хаалт/, 700 ширхэг нэг удаагийн бээлий, 200 ширхэг санитол, 20 ширхэг нойтон сальфетка олгоод байна.





Үйлчлэгээний танхимд үйлчлүүлэгч иргэдэд 2 метрийн зай барин үйлчлүүлэх анхааруулга бүхий тэмдэглэгээг шаланд байрлуулсан.










УОК-ын 2020 оны 04 дүгээр сарын 16 ны өдрийн “Амны хаалтаа зүүцгээе” аяны хүрээнд албан хаагчид амны хаалттай профайл зураг тавих, найз нөхөд болон бусад төрийн байгууллагуудыг амны хаалт зүүх челленжид дуудах зэрэг ажиллагааг зохион байгуулж байна.

### *11.4. Ариутгал цэвэрлэгээний талаар*

Хэлтсийн хэмжээнд халдвараас хамгаалах хэрэгсэл, ариутгал, цэвэрлэгээний бодисын нөөц бүрдүүлсэн. Үүнд: биеийн дулаан хэмжигч аппарат, амны хаалт, нэг удаагийн бээлий, санитол, нойтон сальфетка, 5 литр эмнэлгийн спирт, ариутгал, цэвэрлэгээний бодисууд /жавилеон, хлорамин, гарын болон барааны саван, угаалгын нунтаг/.

Орхон аймгийн МХГ-ын Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагчийн зөвлөмжийн дагуу цэвэрлэгээ үйлчилгээ хийн 2 цаг тутамд хаалганы бариул, үйлчилгээний цонх, иргэдэд үйлчлэх ширээ гэх мэт иргэдэд ихээр хүрэлцдэг, түргэн бохирдож буй эд хогшлыг ариутган цэвэрлэж байна.





Мөн аймгийн Засаг даргын А/192 захирамжийн дагуу 2020.03.31 ний өдөр байгууллагын орчны хариуцсан талбайд их цэвэрлэгээ зохион байгууллаа.

2020.04.24 ны өдөр Хэлтсийн ажлын байранд их цэвэрлэгээ, ариутгалын зохион байгуулсан.







## 12. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БОЛОН АНСДИТХ-ЫН 2020 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН ТАЛААР

**Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, АНСДИТХ-ын сонгуулийн тухай хууль болон УБЕГ-ын даргын баталсан ээлжит сонгуулийн**

**тухай хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөө, СЕХ-ны тогтоолыг хэрэгжүүлэн ажилласан.**

| № | Зохион байгуулсан ажил | Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгууль | АНСДИТХ-ын ээлжит сонгууль |
|---|---|---|---|
| 1 | Иргэний шилжилт хөдөлгөөн түр зогсоосон. | УБЕГ-ын даргын 2020.01.27 ны өдрийн А/126 тушаалаар 2020.01.31 ний өдрөөс зогсоосон | УБЕГ-ын даргын 2020.08.07 ны өдрийн А/1168 тушаалаар 2020.08.16 ны өдрөөс зогсоосон. |
| 2 | Тойргийн дугаар | 20 | - |
| 3 | Хэсгийн хорооны тоо | 38 | 37 |
| 4 | Итгэмжлэгдсэн ажилтны тоо | 70 | 40 |
| 5 | Итгэмжлэгдсэн ажилтны “Эрх зүй”-н сургалт | 2020.05.15 нд онлайнаар | 2020.09.07 нд онлайнаар |
| 6 | Итгэмжлэгдсэн ажилтны “Ирц бүртгэл”-ийн программын сургалт | 2020.06.11-12 нд танхимаар  | 2020.10.02 нд танхимаар  |
| 7 | Сонгогчийн шилжилт | Сонгогч шилжин ирсэн 176<br>Сонгогч шилжин явсан 138 | |
| 8 | СНЖ-д өөрчлөлт оруулсан хэвлэсэн лавлагааны тоо | 347 | 29 |
| 9 | СНЖ хэвлэсэн огноо | 2020.05.27 нд  | 2020.09.17 нд  |
| 10 | СНЖ хэсгийн хороодод хүргүүлсэн огноо | 2020.05.29 нд | 2020.09.19 нд |
| 11 | Санал хураах өдөр | 2020.06.24 | 2020:10:15 |

| | | | |
|---|---|---|---|
| 12 | Ноцтой зөрчил гарсан эсэх | Гараагүй хэвийн | Гараагүй хэвийн |

## 12. НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ТАЛААР

Албан хаагчдын бие бялдрыг хөгжүүлэх, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор нийт албан хаагчдыг “Йог”-ийн сургалтад хамруулсан.



“Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр” буюу хүүхдийн баярыг угтан хэлтсийн албан хаагчдын хүүхдүүдийн дунд “Шилдэг хүүхэд” шалгаруулах уралдаан зохион байгуулж 3 хүүхдийг шалгаруулан шагнаж урамшуулсан.

Мөн нийт албан хаагчдын хүүхдүүд болох 0-16 насны 55 хүүхдэд эцэг эхээр дамжуулан бэлгийг хүргүүлсэн.





Тус хэлтсээр үйлчлүүлж буй нялх хүүхэдтэй эхчүүд болон балчир насны хүүхдүүдийг саатуулах, хуурайлах, хөхүүлэх булан бэлтгэн тохижуулсан.





Монгол улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлигаар намрын “Бүх нийтээр мод тарих” өдөр Баянцагаан багт байрлах “Ногоон пасспорт” төгөлд 2 төрлийн 26 ширхэг мод тарьсан.





**12. ДҮГНЭЛТ, ЦААШДЫН ЗОРИЛТ**

Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс 2020 оны эхний хагас жилд хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн ажлаа бүрэн хийж гүйцэтгэлээ.

Тайлангийн хугацаанд Монгол Улсын Их Хурлын болон АНСДИТХ-ын сонгуулийн тухай хууль тогтоомжоор хүлээсэн ажлыг ханган ажиллаж тус ээлжит сонгуулийн үйл ажиллагааг амжилттай зохион байгууллаа.

Мөн COVID-19 холбоотойгоор УБЕГ-ын даргын тушаалаар Ажлын цагийн тусгай горимоор ажилласан бөгөөд иргэдэд байгууллагын болон, бүртгэлийн үйл ажиллагааны талаархи мэдээллийг цахим хуудсаар сурталчлах ажлыг өргөнөөр зохион байгуулсан.

Монгол улсад бүртгэлийн байгууллага үүсч хөгжсөний 80 жилийн ойн хүрээнд зохион байгуулах ажлын төлөвлөгөөнд тусгагдсан зарим ажлууд Монгол улсын Засгийн газар, Улсын онцгой комиссоос улсын хэмжээнд бүх нийтийн болон өндөржүүлсэн бэлэн байдал зарласантай холбоотойгоор хэрэгжээгүй болно.

2021 онд тус хэлтэс нь дараах ажил, арга хэмжээн дээр анхааран ажиллах болно.

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийг бүртгэлийн хэлтсийн зүгээс амжилттай зохион байгуулах
2. Төрийн албаны тухай хууль, түүнийг дагалдан гарсан журмуудыг хэрэгжүүлэн ажилллах
3. Бүртгэлийн үйлчилгээний стандарт болон төрийн албан хаагчийн ёс зүйтэй холбоотой асуудлыг анхаарах, олон талт ажил, арга хэмжээг зохион байгуулах
4. Хэлтсийн хэмжээнд авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар албан хаагчдын дунд тодорхой ажил зохион байгуулах
5. Үйлчлүүлэгч, харилцагчид үйлчилгээ авахад ая тухайтай байх орчин нөхцөл, чирэгдэлгүй шуурхай үйлчлилгээ үзүүлэх тал дээр ажил зохион байгуулах
6. Албан хаагчдын эрх зүйн мэдлэг болон ажлын ур чадварыг дээшлүүлэх талаар сургалтын болон бусад арга хэмжээнүүдийг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх
7. Алба хаагчдын эрүүл мэнд, нийгмийн асуудлыг шийдвэрлэх тал дээр анхаарлаа чиглүүлэн ажиллах болно.

**ОРХОН АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС**